**БОГД БАНК**
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНК ХК-ИЙН 2022 оны

2-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа* | 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 30-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Компанийн нэр: БОГД БАНК<br>УБГД: 9007001005<br>Үнэт цаасны код: MN0BOGD05580<br>Утасны дугаар: (+976) 7577-1199 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Банк, Санхүү |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 62,500,000 |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Ч.Банчин<br>Бизнес хөгжил хариуцсан дэд захирал |

| | | |
|---|---|---|
| *1.* | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /Хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана.* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | 2-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт №1/ |
| | *Орлогын тайлан* | |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | |
| | | |
| *2.* | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт* | |
| | Банк нь 2021-2025 оны бизнес болон тоон төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан бөгөөд 2022 оны тоон төлөвлөгөөг танилцуулан батлуулж, танилцуулгыг хувьцаа эзэмшигчиддээ ээлжит хурлаар нээлттэй танилцуулсан. Улмаар үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд сар бүр Удирдлагын хороон дээр үр дүнгээ хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. | |
| *3.* | *Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт* | |
| *3.1.* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | **Өөрийн хөрөнгө:** Богд банк ХК нь 2014 оны 11 сард үүсгэн байгуулагдаж, тухайн санхүүгийн жилээ 16.07 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэйгөөр өндөрлөсөн байсан. Харин 2022 оны 2-р улирлын байдлаар өөрийн хөрөнгөө 107.04 тэрбум төгрөгт хүргэж, 566%-иар өсгөж чадсан ба сүүлийн 5 жилийн дундаж өсөлт нь 32%-тай байна.<br>**Нийт хөрөнгө:** Нийт хөрөнгийн дүн 2014 онд 16.66 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 2-р улирлын байдлаар 393.83 тэрбум төгрөгт хүрч 2,264%-иар нэмэгдсэн ба жилд дунджаар 52%-ийн өсөлт үзүүлжээ.<br>**Капитал үржүүлэгч:** Өөрийн хөрөнгийг нийт хөрөнгөнд харьцуулсан үзүүлэлт 2014 онд 1.04 байсан бол 2022 оны 2-р улирлын байдлаар 3.68 |

<table>
<tr><td></td><td></td><td>болж, 255% өссөн нь бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн өсөлтийг харуулах бөгөөд өсөлтийн хувь их байгаа нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж буйн илэрхийлэл болно.<br>Цэвэр хүүний маржин: 2022 оны эхний хагас жилд тайлант үеийн цэвэр ашиг 8.03 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны үеэс 16%-иар өссөн үзүүлэлт болох ба цэвэр хүүний маржин 2021 онд 5.87% байсан бол тайлант хугацаанд 6.17% болж 0.30 функтаар өссөн. Цэвэр хүүний маржин өссөн нь хөрөнгийн үр ашигт байдал сайжирч, ашигт ажиллагаа нэмэгдсэн болохыг илэрхийлж байна</td></tr>
<tr><td>3.2.</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжит үзүүлэлт</td><td>
<table>
<tr><th>Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</th><th>Байвал зохих</th><th>Биелэлт</th></tr>
<tr><td>Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа</td><td>9%</td><td>39%</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа</td><td>12%</td><td>39%</td></tr>
<tr><td>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</td><td>25%</td><td>35%</td></tr>
<tr><td>Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)</td><td>15%</td><td>2%</td></tr>
<tr><td>Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)</td><td>40%</td><td>2%</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>3.3.</td><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компаний зүгээс авч буй хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</td><td>Банк нь тайлант хугацаанд дараах арга хэмжээнд оролцож, борлуулалтаа нэмэгдүүлэхээс гадна өөрсдийн үйл ажиллагааг танилцуулж, идэвхтэй ажиллалаа. Үүнд:
<ul>
<li>"Ipo Mongolia 2022 Forum" арга хэмжээнд Богд банк ХК нь өөрсдийн бүтээгдэхүүний үйлчилгээ болон банкны хувьцааны талаар сонирхсон иргэдэд мэдээлэл өгч оролцов.</li>
<li>Нийт хувьцаа эзэмшигчиддээ зориулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулав.</li>
<li>Монголын банкны холбоооос жил бүр зохион байгуулдаг “Банкны ажилтны өдөр”-ийн аяны хаалтын үйл ажиллагаанд “<u>Бид банкир</u>” ногоон ирээдүйг бүтээлцэнэ уриан дор зохиогдсон ба “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд богд ууланд банкируудын тоглолийг байгуулав.</li>
<li>Жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярыг угтан “Хүсэл түгээнэ” хүүхдийн хадгаламжийн урамшуулалт аяныг амжилттай зохион байгуулав.</li>
<li>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй төсөв, санхүүжилтийн шинэчлэл, боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд багш нарын нийгмийн баталгааг дэмжих зорилгоор “<u>Багш</u>” картын үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагаагэхлүүлэв.</li>
<li>Богд банк ХК, Зээлийн батлан даалтын сан болон Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвтэй хамтран жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг дэмжих, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд цогц санхүүгийн мэдлэг олгох зорилготой 3 талт хамтын ажлыг эхлүүлэв.</li>
</ul>
Мөн шинээр зах зээлд Байгууллагын харилцагчдадаа зориулж <u>Corporate Gateway</u> үйлчилгээ, <u>Prime</u>, <u>Prime Reserve</u> кредит картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв. Мөн харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | тулгуурлан хугацаатай хадгаламжаа хоногийн хугацаагаар сонгох боломжийг бий болгов. |
| *3.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* | Банк нь Монгол улсын засгийн газраас Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад дотоод болон гадаадын төсөл хөтөлбөрт идэвхтэй оролцож буй бөгөөд холбогдох зээлийн багц худалдалт болон санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажлыг олон улсын санхүүгийн нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу бүртгэн ажиллаж байна. |

*4.* *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*

Банк холбогдох мэдээллийг улирал бүр өөрийн цахим хуудсанд байршуулдаг бөгөөд 2022 оны 2-р улирлын тайлан мэдээ дараах байдалтай байна. Үүнд:

| **Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)** | | **Активын хэлбэр** | **Үлдэгдэл дүн** | **Өөрийн хөрөнгөд эзлэх хувь** |
|---|---|---|---|---|
| **1** | Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй) | | | |
| 1.1. | Банкны хувьцаа эзэмшигч | Зээл, бусад | 1,633.93 | 1.53% |
| 1.2. | Банкны эрх бүхий албан тушаалтан | Зээл, бусад | 714.23 | 0.67% |
| 1.3. | Банкны бусад холбогдох этгээд | Зээл, бусад | 1,860.00 | 1.75% |
| **2** | Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй) | | | |
| 2.1. | Банкны нийт хувьцаа эзэмшигч | Зээл, бусад | 1,633.93 | 1.53% |
| 2.2. | Банкны эрх бүхий албан тушаалтнууд | Зээл, бусад | 2,276.92 | 2.14% |
| 2.3. | Банкны бусад холбогдох этгээд | Зээл, бусад | 6,207.65 | 5.83% |

*5.* *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл*

Банк нь үнэт цаас гаргах төсөл гаргахдаа татан төвлөрүүлсэн хөрөнгийг 3 жилийн хугацаанд дараах 3 чиглэлээр зарцуулахаар төлөвлөсөн. Технологийн хөрөнгө оруулалт, Бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэлт болон Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт чиглэлээр зарцуулахаар байгаа.
Богд банк ХК нь анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон худалдах хүсэлт болон холбогдох бичиг баримт, төсөв, төлөвлөгөөг 2021 оны 6 дугаар сард МХБ, Монголбанк болон СЗХ-нд хүргүүлсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудын шаардлагаар дахин 2021 оны 8 дугаар сард шинэчлэн хүргүүлсэн. Монголбанк, СЗХ-ны хамтарсан журам 2021 оны 11 дүгээр сард батлагдаж улмаар СЗХ-ноос Богд банкинд үнэт цаасаа олон нийтэд арилжих зөвшөөрлийг олгосон даруйд 12 дугаар сарын 1-ээс 7-ны өдрүүдэд анхдагч захын арилжаа зохион байгуулж 12 дугаар сарын 13-ны өдрөөр холбогдох гүйлгээнүүд хийгдсэн тул 2021 онд төлөвлөж байсан зарцуулалтууд хойшилсон болно. 2022 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар татан төвлөрүүлсэн 31,750 сая төгрөгөөс нийт 12,715.90 сая төгрөг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зарцуулагдсан байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл 19,034.10 сая төгрөг нь актив талд энгийн зээл олголтонд болон Төв банкны үнэт цаас, монголбанк дахь харилцах данс зэрэгт байршсан болно.

*6.* *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

Компанийн засаглалын тайлан хуулийн хугацаанд нь гаргаж байна. Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам кодексыг шинэчлэн батлахаар бэлтгэж байна.

*7.* *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл.*

| | |
|---|---|
| | Компанийн засаглалын тайлан хуулийн хугацаанд нь гаргаж, холбогдох сайт болон нийтэд мэдээллэсэн. Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам кодексыг шинэчлэн батлахаар бэлтгэж байна. |
| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: | |
| Овог нэр: Г.САРУУЛ<br><br>Албан тушаал: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br><br>Гарын үсэг: ..............................................<br><br>(Тамга, тэмдэг) БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ 5903858 9021111168 | |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: | |
| Овог нэр: Ч.БАНЧИН<br><br>Албан тушаал: БИЗНЕС ХӨГЖИЛ ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ<br><br>Гарын үсэг: .............................................. | |

# БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
# SUMMARY BALANCE SHEET OF BOGD BANK

*(мянган төгрөг)*

| № | Балансын зүйл | Balance sheet | 2022.06.30 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | **ASSETS** | |
| 1.1 | **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө** | **Cash and cash equivalents** | **49,936,059.8** |
| 1.2 | **Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө** | **Deposits and placements in banks and financial institutions** | **22,856,473.6** |
| 1.3 | **Хөрөнгө оруулалт** | **Financial investments** | **105,499,728.9** |
| 1.3.1 | Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | Investments in subsidiaries, associates and jointly controlled entities | 0.0 |
| 1.4 | **Зээл (цэвэр дүнгээр)** | **Loans (net)** | **202,369,947.7** |
| 1.4.1 | Хэвийн зээл | High grade | 173,333,780.0 |
| 1.4.2 | Хугацаа хэтэрсэн зээл | Standard | 22,800,177.7 |
| 1.4.3 | Чанаргүй зээл | Non-performing loan | 6,739,555.3 |
| 1.4.4 | Зээлийн хойшлогдсон төлбөр | Deferred loan payment | 0.0 |
| 1.4.5 | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | Accrued interest receivable on loans | 2,765,273.5 |
| 1.4.6 | Зээлийн эрсдэлийн сан | Provision for loan losses | (3,268,838.80) |
| 1.5 | **Дериватив санхүүгийн хөрөнгө** | **Derivatives financial assets** | 24,380.7 |
| 1.6 | **Бусад санхүүгийн хөрөнгө** | **Other financial assets** | 524,644.1 |
| 1.7 | **Бусад санхүүгийн бус хөрөнгө** | **Other non-financial assets** | 3,607,317.1 |
| 1.8 | **Үндсэн хөрөнгө** | **Fixed assets** | 7,005,370.3 |
| 1.9 | **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө** | **Investment property** | 0.0 |
| 1.10 | **Борлуулах зориулалттай хөрөнгө** | **Assets held for sale** | 1,024,770.0 |
| 1.11 | **Биет бус хөрөнгө** | **Intangible assets** | 984,226.2 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **Total assets** | **393,832,918.4** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР** | **LIABILITY** | |
| 2.1 | **Харилцах, хадгаламж** | **Current accounts & Deposits** | **176,059,299.8** |
| 2.2 | **Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр** | **Due to banks and financial institutions** | 27,564,841.2 |
| 2.3 | **Бусад эх үүсвэр** | **Other funding** | 78,180,509.6 |
| 2.4 | **Дериватив санхүүгийн өр төлбөр** | **Derivative financial liabilities** | 0.0 |
| 2.5 | **Бусад санхүүгийн өр төлбөр** | **Other financial liabilities** | 2,708,203.4 |
| 2.6 | **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | **Other non-financial liabilities** | 2,273,614.1 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **Total assets** | **286,786,468.1** |
| 3 | **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **EQUITY** | |
| 3.1 | **Хувь нийлүүлсэн хөрөнгө** | **Share capital** | **100,000,000.0** |
| 3.2 | **Нэмж төлөгдсөн капитал** | **Share premium** | (1,443,177.70) |
| 3.3 | **Халаасны хувьцаа** | **Treasury shares** | 0.0 |
| 3.4 | **Дахин үнэлгээний нэмэгдэл** | **Revaluation surplus** | 0.0 |
| 3.5 | **Хуримтлагдсан ашиг, алдагдал** | **Retained earnings** | **10,344,342.90** |
| 3.6 | **Бусад өөрийн хөрөнгө** | Other equity | (1,854,714.90) |
| 3.7 | **Өөрийн хөрөнгийн дүн** | Total equity | **107,046,450.3** |
| 4 | **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **Total liabilities and equity** | **393,832,918.4** |

| Тэнцлийн гадуурх данс | Off-balance sheet | |
|---|---|---|
| Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр) | Contingent liabilities and commitments | **20,442,533.8** |

# БОГД БАНК ХК-ИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
# INCOME STATEMENT

*(мянган төгрөг)*

| № | Орлого, зардлын зүйл | Income and expenses | 2022.06.30 |
|---|---|---|---|
| **1** | **Хүүгийн орлого** | **Interest income** | **18,552,996.7** |
| 1.1 | Монголбанкинд байршуулсан хөрөнгийн | Deposit with the Bank of Mongolia | 45,972.6 |
| 1.2 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | Deposits and placements in banks and financial institutions | 527,578.3 |
| 1.3 | Үнэт цаасны | Securities | 4,437,990.9 |
| 1.4 | Зээлийн | Loans | 13,431,640.7 |
| 1.5 | Бусад хүүгийн орлого | Other interest income | 109,814.2 |
| **2** | **Хүүгийн зардал** | **Interest expense** | **6,408,661.1** |
| 2.1 | Харилцахад төлсөн хүү | Interest paid in current accounts | 0.0 |
| 2.2 | Хадгаламжинд төлсөн хүү | Interest paid in deposit accounts | 4,386,603.3 |
| 2.3 | Зээлийн хүүгийн зардал | Loan interest expense | 11,216.1 |
| 2.4 | Үнэт цаасны хүүгийн зардал | Securities interest expense | 2,007,717.6 |
| 2.5 | Бусад хүүгийн зардал | Other interest expense | 3,124.1 |
| **3** | **Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]** | **Interest income (net) [(1)-(2)]** | **12,144,335.6** |
| **4** | **Эрсдэлийн сангийн зардал** | **Provision expense** | **1,149,384.1** |
| 4.1 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | Deposits and placements in banks and financial institutions | 0.0 |
| 4.2 | Үнэт цаасны | Securities | 0.0 |
| 4.3 | Зээлийн | Loans | 1,149,384.1 |
| **5** | **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]** | **Net interest income after provision [(3)-(4)]** | **10,994,951.5** |
| **6** | **Бусад орлого** | **Other income** | **7,075,098.2** |
| **6.1** | **Хүүгийн бус орлого** | **Non interest income** | **7,007,800.7** |
| 6.1.1 | Арилжааны орлого | Trading income | 1,373,858.9 |
| 6.1.2 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | Income on foreign currency exchange and revaluation | 3,614,895.7 |
| 6.1.3 | Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | Fee and commissions income | 1,512,887.6 |
| 6.1.4 | Бусад хүүгийн бус орлого | Other non interest income | 506,158.5 |
| **6.2** | **Бусад орлого, олз** | **Other income and gains** | **67,297.5** |
| **7** | **Бусад зардал** | **Other expense** | **9,002,162.0** |
| **7.1** | **Хүүгийн бус зардал** | **Other non interest expense** | **8,968,600.2** |
| 7.1.1 | Бусад эрсдэлийн сангийн зардал | Other provision expense | 1.4 |
| 7.1.2 | Арилжааны зардал | Trading expense | 711,111.6 |
| 7.1.3 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | Expense on foreign currency exchange and revaluation | 2,309,410.7 |
| 7.1.4 | Хураамж, шимтгэлийн зардал | Fee and commissions expense | 269,393.9 |
| 7.1.5 | Үйл ажиллагааны бусад зардал | Non operating other expenses | 5,678,682.6 |
| **7.2** | **Бусад зардал, гарз** | **Other expenses and losses** | **33,561.8** |
| **8** | **Татварын өмнөх ашиг, алдагдал [(5+6-7)]** | **Profit before tax (5+6-7)** | **9,067,887.7** |
| 9 | Орлогын татварын зардал | Income tax expense | 1,034,386.8 |
| **10** | **Татварын дараах ашиг, алдагдал [(8-9)]** | **Profit after tax** | **8,033,500.9** |
| 11 | Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал | Discontinued Operations net income, expense | **0.0** |
| **12** | **Тайлант хугацааны нийт орлогын дүн [(10+11)]** | **Net profit for the current year (10+11)** | **8,033,500.9** |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | Other comprehensive income/(loss) | (2,783,712.40) |
| 14 | Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13) | Total comprehensive income for the year, net of tax (12+13) | 5,249,788.5 |

**БОГД БАНК**
ХУВЬЦААТ КОМПАНИ

# 2022 ОНЫ II УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## НИЙТ ХӨРӨНГӨ

/сая.төг/




## ЦЭВЭР АШИГ

/сая.төг/




## ХҮҮГИЙН ОРЛОГО

/сая.төг/




## ЗЭЭЛ

/сая.төг/

